

Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2025.12.01

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын зах зээл сул үзүүлэлтүүдийн дунд хүү бууруулах хүлээлт өсөлтөө хадгалж, жижиг хувьцаанууд илүү хүчтэй сэргэлт үзүүлж байна.
- Retail sales, PPI, consumer confidence зэрэг тоонууд эдийн засаг зөөлөн хөрж буйг харуулсан ч энэ нь ХНСС-ийн бодлого зөөлрөх орон зайг нэмэгдүүлжээ.
- S&P 500 дээр H&S унах эрсдэлийн зураг бүрэн хүчингүй болох түвшин 6,950, харин 6,550 доош эвдвэл доошоо чиглэл давамгайлах магадлал өндөр байна.
- Хятадын зах зээлд үйлдвэрлэлийн ашгийн уналт (PPI) 37 сар дараалан сөрөг байгаа нь Хятадын эдийн засаг IV улиралд momentum алдаж буйг харуулж байна.
- Гэсэн ч БНХАУ-д бодлогоор дэмжигдсэн нөхцөл байдал, AI эрэлт, хөрөнгө оруулагчдын sentiment сайжирсан нь Hang Seng-ийг 28–30 мянгад чиглэсэн өсөлтийн циклд байгааг нотолж байна.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна

ОНЦЛОХ ХУВЬЦАА: NVDA КОМПАНИЙН ХУВЬЦААГ \$160 ХАНШИД АВАХ ТОХИРОМЖТОЙ





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.11.24-11.01

АНУ-ЫН ТӨВБАНК 12-Р САРД ХҮҮГЭЭ БУУРУУЛАХ ХҮЛЭЭЛТ 87.4%-Д ХҮРЛЭЭ

Өнгөрсөн долоо хоног АНУ-ын хөрөнгийн зах зээлд эерэг уур амьсгал давамгайлав. Хүүг буурах өнгө аястай ХНС-ийн мэдэгдлүүд болон эдийн засгийн үзүүлэлтүүд сул гарсан нь зах зээлд “12-р сарын хүү буурах магадлал өндөр” гэх мессеж өгсөн тул хөрөнгүүдийн үнэ өсөөд байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ЧУХАЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХҮҮГ БУУРУУЛАХ ТАЛД ГАРЛАА

Энэ долоо хоногийн чухал үзүүлэлтүүдийн нэг нь retail sales буюу хэрэглээний зарцуулалт байлаа. Есдүгээр сарын retail sales ердөө 0.2% өссөн нь наймдугаар сарын 0.6%-аас эрс доогуур, мөн зах зээлийн таамаглалаас сул гарлаа.

Үүнтэй зэрэгцэн бөөний худалдаан үнийг илтгэгч, үйлдвэрлэгчийн үнийн өсөлтийг харуулдаг инфляц болох PPI ердөө 0.3% өсөж, үндсэн инфляц нь (core PPI) 0.1% л өссөн нь инфляцын дарамт царцаж буйг харуулсан үзүүлэлт байв. Түүнчлэн АНУ-ын бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 1.96 саяд хүрч өслөө.

Дээрх 2 мэдээллүүд нь бүгд “soft landing + rate cut” буюу төвбанк хүүг бууруулж, эдийн засаг ойрын хугацаанд зөөлөн газардалт хийх буюу хэвийн түвшинд байх нөхцөлийг бүрдүүлж өглөө.

S&P500 ИНДЕКСИЙН ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ

Хэрэв 6,550 түвшнийг доош эвдвэл 6,150 түвшин хүртэл унах боломжтой. Үүнийг дараах үзүүлэлтүүд дэмжиж байна:

- 1 өдрийн лаагаар харвал зах зээл өсөлтийн трендэд ороогүй байна. (ADX<25)
- Зах зээлийн моментум индекс доош трендээ хадгалсаар байна.
- Хэрэв 6950-аа дээш сэтэлбэл 6,150 хүрэх эрсдэл техникийн хувьд бүрэн арилна. (H&S хэлбэр эвдэгдэж, дахиж үүсэх нөхцөл бүрдэхгүй)



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.11.24– 11.01

ХЯТАДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ӨСӨЛТӨӨ ХАДГАЛСААР БАЙНА

Энэ долоо хоногт Хятадын хөрөнгийн зах зээл огцом сэргэлт үзүүлэв. Дотоодын технологи болон хиймэл оюун (AI) салбарын эрэлт хүчтэй байж, эдийн засгийн удаашралын талаархи болгоомжлолыг дарж өгсөн нь гол шалтгаан боллоо. FactSet-ийн мэдээлснээр, Хятадын дотоодын гол индекс CSI 300 нь 1.64%, Shanghai Composite 1.40% өссөн бол Гонконгийн Hang Seng индекс бүр 2.53%-иар өсөж, бүс нутгийн хамгийн хүчтэй өсөлтүүдийн нэг болов.

БНХАУ-ЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН АШИГТ АЖИЛЛАГАА 5.5%-ИАР БУУРЛАА

- Зах зээлийн өсөлтийн хажуугаар эдийн засгийн талд анхааруулга өгөх дохио гарлаа. Үүнд:
- Хятадын Үндэсний Статистикийн Хороо мэдээлэхдээ, үйлдвэрлэлийн салбарын ашгийн хэмжээ арваннэгдүгээр сард жилийн хувьд 5.5% буурсан байна. Энэ нь зах зээлийг бага зэрэг цочирдуулсан үзүүлэлт байв, учир нь өмнөх хоёр сар дараалан 20%+ өсөлттэй байсан билээ.
 - Ийм уналт гарсан нь дөрөвдүгээр улиралд Хятадын эдийн засгийн өсөлт эрчээ алдаж болзошгүй гэдгийг дахин нотолсон datapoint болж байна.

БНХАУ СҮҮЛИЙН 37 САР ОГТ ҮНИЙН ДАРАМТГҮЙ БАЙЛАА

БНХАУ-ын Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) нь 37 дахь сардаа дараалан сөрөг гарсан нь үнэ буурч буй хандлага хэвээр байна гэдгийг харуулав. Энэ нь дараах салбаруудад үнийн “дайн” үргэлжилж байгааг илтгэнэ:

- Хүнсний салбар
- Автомашин
- Технологийн үйлдвэрлэл
- Үйлдвэрлэлийн хүнд салбарууд

Хэдийгээр Бээжин “anti-involution” хөтөлбөрт ажил өрнүүлж, хэт их үйлдвэрлэл, өрсөлдөөнөөс үүдсэн үнийн бууралтыг зогсоохыг зорьж байгаа ч бодит байдал дээр PPI өргөн хүрээнд дефляцын орчинд хэвээр байна.

Golomt_Capital created with TradingView.com, Dec 01, 2025 11:54 UTC+8

Hang Seng Index · 1D · HSI O25,945.87 H26,179.72 L25,919.08 C26,065.50 -206.61 (+0.80%) -206.61 (-0.80%)



